



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/571

Булган сум

┌ Бэлчээр хамгаалах арга хэмжээ ┐
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/96 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг Улсын төсвийн хөрөнгөөр Рашаант сумын 10.0 мянган га, Дашинчилэн сумын 10.0 мянган га, Сайхан сумын 10 мянган га талбай нийт 30.0 мянган га талбайд тус тус зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар хангаж, ажиллах хүн, хүч, техник хэрэгсэл дайчлах, ажилгүй иргэд болон малчдыг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0334010771